



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хот тохижилт үйлчилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/57/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улиастай сум 2022 он	Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч : Г.Заяа Утас:92038288 Цахим хаяг: zayag@audit.gov.mn Аудитор:Ц.Алтантуул Утас: 91195554 Цахим хаяг : tuul9565@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	10
3.8 Аудитын гол асуудал	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
4. Аудитын илрүүлэлт	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

2022.02.22 № 1302/130
танай _____ -ны № _____ -т

ХОТ ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ

АЛБАНЫ ДАРГЫН ҮҮРЭГ

ХАРИУЦАГЧ Ж. БАТСҮХ-Д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хот тохижилт үйлчилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

4,683.3 мянган төгрөгийн ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл буруу олгосон, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийг шийдвэргүйгээр данснаас хассан, 2,742.0 мянган төгрөгийн хувь хүнд олгосон орлогоос татвар суутгаж тайлагнаагүй, 547.0 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтад тавих хяналт сул, тооцоог бодоогүй зэрэг зөрчил нь (Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31.1, 31.3 дахь заалтууд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6 дахь заалт, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25.1 дэх заалттай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй) байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

013023043

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/сая төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	75.86	50.90
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.89	5.34
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.89	5.34
3121	Төгрөг	0.89	5.34
31212	Монгол банкин дахь харилцах	0.06	5.18
31213	Арилжааны банк дахь харилцах	0.83	0.17
33	АВЛАГА	33.14	13.87
335	Бусад авлага	33.14	13.87
3351	Байгууллагаас авах авлага	3.27	2.67
3352	Хувь хүмүүсээс авах авлага	29.87	11.21
35	БАРАА МАТЕРИАЛ	41.83	31.68
35300	Бэлэн бүтээгдэхүүн	5.13	1.80
354	Хангамжийн материал	35.87	29.89
35410	Бичиг хэргийн материал	1.25	1.04
35420	Аж ахуйн материал	19.49	22.22
35430	Сэлбэг хэрэгсэл	4.15	0.71
35440	Түлш, шатах тослох материал	0.06	0.02
35470	Бусад хангамжийн материал	10.92	5.90
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	738.34	586.66
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	738.34	586.66
392	Биет хөрөнгө	715.82	564.14
39201	Барилга, байгууламж, орон сууц	369.09	369.09
39202	Хуримтлагдсан элэгдэл	(85.29)	(148.62)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	658.08	674.08
39204	Хуримтлагдсан элэгдэл	(580.64)	(616.48)
39205	Машин тоног төхөөрөмж	91.81	91.81
39206	Хуримтлагдсан элэгдэл	(72.65)	(79.10)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	55.59	55.59
39208	Хуримтлагдсан элэгдэл	(50.75)	(52.39)
39214	Бусад үндсэн хөрөнгө	808.44	808.44
39215	Хуримтлагдсан элэгдэл	(477.86)	(538.29)
393	Биет бус хөрөнгө	22.53	22.53
39301	Програм хангамж	0.38	0.38
39302	Хуримтлагдсан элэгдэл	(0.38)	(0.38)
39303	Бусад биет бус хөрөнгө	22.53	22.53
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	814.21	637.56
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	814.21	637.56
51	Засгийн газрын хувь оролцоо	814.21	637.56
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	607.06	607.06
51101	Өмч: - төрийн	607.06	607.06

512	Хуримтлагдсан үр дүн	170.36	(6.28)
51210	Өмнөх үеийн үр дүн	170.36	170.36
51220	Тайлант үеийн үр дүн	-	(176.64)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	36.78	36.78
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	814.21	637.56

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/сая төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,025.72	719.28
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	180.47	102.22
120	Нийтлэг татварын бус орлого	180.47	102.22
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	173.33	94.80
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	133.33	78.80
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	40.00	16.00
120009	Бусад орлого	6.58	7.42
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	845.25	617.06
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	65.40	6.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	65.40	6.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	761.18	590.69
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	761.18	590.69
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	18.67	20.37
1330	Төсвийн захирагчдаас	18.67	20.37
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,215.18	895.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,215.18	895.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,113.23	815.28
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	812.13	647.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	812.13	647.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	301.10	167.68
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	226.10	167.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	101.95	80.65
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	101.95	80.65
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	101.95	80.65
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(189.47)	(176.64)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(191.09)	(176.64)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан / сая төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	603.27	36.78	361.45	1,001.50
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	603.27	36.78	361.45	1,001.50
C07	Тайлант үеийн үр дүн	3.80	-	(191.09)	(187.29)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	607.06	36.78	170.36	814.21
D01	2021 оны 01-р сарын 1-нээрх үлдэгдэл	607.06	36.78	170.36	814.21
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	607.06	36.78	170.36	814.21
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(176.64)	(176.64)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	607.06	36.78	(6.28)	637.56

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/сая төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	988.18	722.08
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	142.93	105.02
120	Нийтлэг татварын бус орлого	142.93	105.02
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	135.79	97.43
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	134.01	97.43
120009	Бусад орлого	6.58	7.59
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	845.25	617.06
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	65.40	6.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	65.40	6.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	779.85	611.06
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	761.18	590.69
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	18.67	20.37
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	990.65	717.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	990.65	717.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	888.70	636.98
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	813.70	636.98

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	813.70	636.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	101.95	80.65
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	101.95	80.65
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	101.95	80.65
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(2.48)	4.45
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(2.48)	4.45
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3.37	0.89
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.89	5.34

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/сая төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	717.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	717.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	636.98
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	636.98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	636.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	0.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	80.65
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	80.65
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	611.06	714.49
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	611.06	611.06
132001	Орон нутгийн төсвөөс	589.14	590.69
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	97.43
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	97.43
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.89
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	5.34
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	0.00	0.00
620001	Удирдах ажилтан	0.00	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	0.00	0.00
620003	Үйлчлэх ажилтан	0.00	0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хот тохижилт үйлчилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Интер Аудит ХХК-ийн гэрээт аудитор Ц.Алтантуул гүйцэтгэж, хяналтыг Интер Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр, Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежерийн үүрэг гүйцэтгэгч Г.Заяа, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Хот тохижилт үйлчилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 02 дүгээр сарын 07-ны өдрийн 07 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хот тохижилт үйлчилгээний алба нь Улиастай сумын айл өрх, албан газар, орон сууц, зам талбайд цэвэрлэгээ үйлчилгээ хийж, хог хаягдлыг цаг алдалгүй ачиж тээвэрлэх, нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлгийн засвар үйлчилгээг хийж гүйцэтгэх, хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх хамгаалах, эзэнгүй үүссэн хог хаягдлыг ачиж зайлуулах зэрэг үндсэн зорилтуудыг дэвшүүлэн ажилласан.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж дүгнэлээ.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хот тохижилт үйлчилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны эхний хагас жилийн нийт зардлын 611.0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 9.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардал 895.9 сая төгрөгийн 1.5 хувь буюу 13.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг түүний 75 хувь буюу 10.0 сая төгрөгөөр тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

дд	Дансны нэр	Тайлант оны эхний үлдэгдэл	Тайлант оны эцсийн үлдэгдэл	Зөрүү
1	МӨНГӨН ХӨРӨНГӨ	893.13	5,341.96	(4.4)
2	АВЛАГА	33,142.01	13,874.94	19.2
4	БАРАА МАТЕРИАЛ	41,827.89	31,682.91	10.1
5	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	738,342.94	586,662.89	151.6
6	Засгийн газрын хувь оролцоо	814,205.98	637,562.70	176.6
7	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	814,205.98	637,562.70	176.6

Авлагын данс 19.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны авлагын барагдуулалттай холбоотой байна.

Бараа материалын данс 10.1 мянган төгрөгөөр буурсан нь бараа материалыг зөвшөөрөлгүй данснаас хассантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 151.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардал өндөр тооцогдсонтой холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 176.6 мянган төгрөг болж буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 611,058.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 611,058.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 590,686.4 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 20,371.8 мянган төгрөгийн, бусад орлого 111,017.2 нийт 722,075.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 717,626.6 мянган төгрөгийг зарцуулсан байна. Тайлант оны мөнгөн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 893.1 мянган төгрөг байсан бөгөөд эцсийн үлдэгдэл 5,341.9 мянган төгрөг болсон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт төсвийн санхүүжилт ороогүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

2022 онд Хот тохижилт үйлчилгээний албыг Улиастай сумын ЗДТГ-тай нэгтгэх шийдвэр гарсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Ажилчдад хавсран ажилласны нэмэгдлийг илүү тооцож олгосон, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай болон хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг мөрдөж ажиллаагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 127 мэдээлэл, хугацаа хоцроосон 22 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэхэд шилэн дансанд мэдээлэл байршуулахдаа хугацаа хоцроосон байгаад анхаарч ажиллах шаардлагатай байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагын төсвийн хуваарь болон зарцуулалтыг анхаарах

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 18.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 13.6 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

4.2 Төлбөрийн акт тогтоогоогүй.

4.3 Албан шаардлага

2 ажилтанд хавсран ажилласны нэмэгдэл 4.6 сая төгрөгийг илүү тооцож олгосон бөгөөд тус ажилтнууд нь бүтцийн өөрчлөлтөөр ажлаас гарсан тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

- ✓ 10.3 сая төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийг шийдвэргүйгээр данснаас хассан;
- ✓ 2.3 сая төгрөгийн хувь хүнд олгосон орлогыг татварын тайланд тусгаагүй, баримтын бүрдүүлэлтийг хангаж ажиллаагүй;
- ✓ 0.5 сая төгрөгийн шатахууны зарцуулалтад тавих хяналт сул, жолоочийн тооцооны хуудсыг бүрэн бөглөөгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг хэрэгжүүлэн, бараа материалыг данснаас хасахдаа өмч хамгаалах зөвлөлөөр шийдвэр гаргуулж хэвших
- ✓ ХХОАТ-ын тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах
 - Албан татвар суутгах орлогыг ТТ-12 тайлангаар мэдээлэх
 - Хувь хүнээс и баримт гаргуулан авах
 - Хувь хүнд и баримт байгууллагын эрхээр шивж баталгаажуулах гэсэн 3 хэлбэрээс сонгон баримтжуулах
- ✓ Жолоочийн тооцооны хуудсыг бүрэн бичиж холбогдох баримтын бүрдлийг бүрэн хангуулан жолоочийн тооцоог бодох

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1.	Хот тохижилт үйлчилгээний алба	4	18.2					1	4.6	3	13.6